

# ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дархан хотын соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/4/НА-СТА-ОНА

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
5.1 Албан шаардлага .....	9
5.2 Зөвлөмж .....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.05.13 № 183

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан хотын соёл амралтын хүрээлэн" ОНӨААТҮГ -ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын даргын тушаал шийдвэргүй 118,445.5 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан, байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралтай ажлуудыг гүйцэтгэж ажилчдад илүү цаг олгосон, санхүүгийн болон бусад захиргааны ажилчдын ажлын байрны тодорхойлолтод тусгасан өөрсдийн үндсэн ажил үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс илүү цагийн нэмэгдэл олгосон, онцгой нөхцөл үүсээгүй, шийдвэргүй, үндэслэлгүй илүү цагийн нэмэгдэл хөлсийг 55,428.2 мянган төгрөгийг тооцон хавтгайруулан олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон 27,000.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" Тарийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцээгүй тул санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4520050019

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд өөрийн үйл ажиллагаанаас 900,000.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 1,004,945.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, орлогын төлөвлөгөө 1,049.5 мянган төгрөгөөр буюу 100 хувь биелүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудлууд**

"Цас эрчис" ХХК нь барилга барих явцдаа тус байгууллагын ногоон байгууламжийг устгасны төлөө нөхөн сэргээх 10,386.9 мянган төгрөгийг нэхэмжлэн санхүүгийн тайланд авлага үүсгэсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 53 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 94.8 хувиар тайлагнасныг Дархан сумын засаг даргын тамгын газраас дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



9022400  
851764270

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны	Тайлант оны
		гүйцэтгэл	гүйцэтгэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	379,762,744.83	523,719.32
1.1.2	Дансны авлага	2,390,288.25	15,841,936.63
1.1.6	Бараа материал	109,149,741.80	167,008,527.51
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>491,302,774.88</b>	<b>183,374,183.46</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,325,606,116.86	8,798,825,721.01
1.2.2	Биет бус хөрөнгө	22,879,872,222.40	22,878,230,222.52
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>31,205,478,339.26</b>	<b>31,677,055,943.53</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,696,781,114.14</b>	<b>31,860,430,126.99</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	1,350,755.60	
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,350,755.60</b>	<b>-</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,350,755.60</b>	<b>-</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	32,651,564,186.37	34,286,216,309.96
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
<b>2.3.9</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(956,133,827.83)</b>	<b>(2,425,786,182.97)</b>
2.3.9	Тайлан үеийн үр дүн	(956,133,827.83)	(956,133,827.83)
2.3.10	Хуримтлагдсан ашиг		(1,469,652,355.14)
<b>2.3.12</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>31,695,430,358.54</b>	<b>31,860,430,126.99</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>31,696,781,114.14</b>	<b>31,860,430,126.99</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,023,800,000.00</b>	<b>1,932,042,277.03</b>
2	Борлуулалтын өртөг		
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,023,800,000.00</b>	<b>1,932,042,277.03</b>

4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	750,564,750.86	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,353,452,950.98	3,401,502,772.17
11	Санхүүгийн зардал	4,572,271.32	191,860.00
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(583,660,471.44)</b>	<b>(1,469,652,355.14)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(583,660,471.44)</b>	<b>(1,469,652,355.14)</b>
21	Үндсэн хөрөнгө худалдсаны олз (гарз)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(583,660,471.44)</b>	<b>(1,469,652,355.14)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,774,364,750.86</b>	<b>1,932,042,277.03</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>32,228,894,779.07</b>	<b>(372,473,356.39)</b>	<b>31,856,421,422.68</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>32,228,894,779.07</b>	<b>(372,473,356.39)</b>	<b>31,856,421,422.68</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(583,660,471.44)	<b>(583,660,471.44)</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт	422,669,407.30		<b>422,669,407.30</b>

7	Зарласан ногдол ашиг			-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	<b>2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>32,651,564,186.37</b>	<b>(956,133,827.83)</b>	<b>31,695,430,358.54</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>32,651,564,186.37</b>	<b>(956,133,827.83)</b>	<b>31,695,430,358.54</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(1,469,652,355.14)	<b>(1,469,652,355.14)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт	1,634,652,123.59		<b>1,634,652,123.59</b>
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	<b>2025 оны 12-р сары 31-ний үлдэгдэл</b>	<b>34,286,216,309.96</b>	<b>(2,425,786,182.97)</b>	<b>31,860,430,126.99</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,774,364,750.86</b>	<b>1,924,745,546.76</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	750,564,750.86	996,416,619.56
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		5,835,250.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	1,023,800,000.00	919,800,000.00
	Бусад мөнгөн орлого		2,693,677.20
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,399,101,553.32</b>	<b>2,241,168,372.27</b>
	Ажиллагчдад төлсөн	884,215,978.77	1,093,043,172.66
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	103,617,236.41	288,384,185.42
	Бараа материал худалдан авахад төлсөн	38,264,135.40	22,811,474.00
	Ашиглалтын зардалд төлсөн	109,666,572.42	153,789,953.89
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	136,458,442.00	21,056,400.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	24,652,352.00	25,140,976.06
	Даатгалын төлбөрт төлсөн		800,000.00
	Бусад мөнгөн зарлага	102,226,836.32	636,142,210.24
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>375,263,197.54</b>	<b>(316,422,825.51)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		

	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>54,020,500.00</b>	<b>62,816,200.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	54,020,500.00	62,816,200.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(54,020,500.00)</b>	<b>(62,816,200.00)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>321,242,697.54</b>	<b>(379,239,025.51)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>58,520,047.29</b>	<b>379,762,744.83</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>379,762,744.83</b>	<b>523,719.32</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Үйлдвэрийн үндсэн үзүүлэлт					
Нийт орлого	1,774,364,750.86	1,819,800,000.00	1,932,042,277.03	112,242,277.03	5.81
Үүнээс: Цэвэр борлуулалт	1,023,800,000.00	919,800,000.00	919,800,000.00	-	-
Бусад орлого	750,564,750.86	900,000,000.00	1,012,242,277.03	112,242,277.03	11.09
Нийт зардал	2,358,025,222.30	2,303,985,874.60	3,401,694,632.17	1,097,708,757.57	32.27
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-			-	
Ерөнхий удирдлагын зардал	2,358,025,222.30	2,303,985,874.60	3,401,694,632.17	1,097,708,757.57	32.27
Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	-			-	
<b>Цэвэр ашиг, алдагдал</b>	<b>(583,660,471.44)</b>	<b>- 484,185,874.60</b>	<b>(1,469,652,355.14)</b>	<b>(985,466,480.54)</b>	<b>67.05</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,873.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup>-д 118,445.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 55,428.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

#### 5.1 Албан шаардлага

Тайлант онд байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 118,445.5 төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 67.2-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Цалинтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт хамааралтай ажлуудыг гүйцэтгэхэд ажилчдад илүү цаг олгосон, санхүүгийн болон бусад захиргааны ажилчдын ажлын байрны тодорхойлолтод тусгасан өөрсдийн үндсэн ажил үүргээ хугацаанд нь

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

хэрэгжүүлээгүйгээс илүү цагийн нэмэгдэл олгосон, онцгой нөхцөл үүсээгүй, шийдвэргүй, үндэслэлгүй илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцон 55,428.2 мянган төгрөгийг хавтгайруулан олгосон нь байгууллагын дүрмийн 4.1.1-д "Хөдөлгөөнт тоглоомын бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээ, аюулгүй байдал болон бусад үйлчилгээг хариуцах", 4.1.2-т "Нийтийн эзэмшлийн талбайд хуулийн хүрээнд нийтийг хамарсан соёл олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах нөхцөлөөр хангах", 4.1.5-д "Хариуцсан газрын ногоон байгууламжийн арчилгаа, тордолт, хамгаалалт, нөхөн тайралтыг хариуцах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 5 дугаар зүйлд "Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 болон 20.2 дахь заалтыг баримтлан, илүү цагийн нэмэгдлийг олгох тухай дотоод журам боловсруулж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 118,445.5 төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.	1	118,445.5			1	118,445.5						
Илүү цагийн нэмэгдлийг хавтгайруулсан олгосон	1	55,428.2					1	55,428.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>173,873.7</b>			<b>1</b>	<b>118,445.5</b>	<b>1</b>	<b>55,428.2</b>	-	-	-	-